

**СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ТООЦОХ, АРИЛГАХ ТАЛААРХ
ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРОН БОЛОН МОНГОЛ УЛСЫН
ТУРШЛАГЫГ
ХАРЬЦУУЛАН ДҮГНЭСЭН БАЙДАЛ**

**EXPERIENCE OF FOREIGN COUNTRIES IN CALCULATING AND
ELIMINATING MORAL DAMAGE**



Ч.Отгонсүрэн

Дотоод хэргийн их сургуулийн

Хилийн албаны сургуулийн ахлах багш,

хууль зүйн ухааны магистр, докторант, дэд хурандаа

Товч агуулга: Сэтгэл санааны хохирлыг тооцож буй олон улсын туршлага, Монгол Улсад хийгдэж байгаа сэтгэл санааны хохирлыг тооцох үнэлгээний аргачлалыг харьцуулан дүгнэлт, саналаа дэвшүүлсэн болно.

Abstract: In this work international experience in calculating moral damage, comparative conclusion of applied methods of calculating moral damage in Mongolia and suggestions are proposed.

Түлхүүр үг: Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирлыг үнэлэх, арилгах талаарх туршлага.

Key word: experience of foreign countries in calculating and eliminating moral damage

Манай Улсад Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хор уршгийг арилгуулахаар шүүхэд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрх зүйн үндсийг зааж өгсөн байдаг. Гэвч эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулиудад гэмт хэргийн улмаас хүний бие, эд хөрөнгөд учирсан бодит хохирол, гэм хорыг арилгах талаар зохицуулалтыг боловсронгуй болгосон боловч эдийн бус гэм хор тэр дундаа сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчин саяхныг хүртэл тодорхойгүй байсан билээ¹²⁷.

¹²⁷ Монгол Улсын үндсэн хууль 16.14

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд, сэтгэл санаанд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг хэрхэн ойлгох, ямар гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг ямар шаардлагыг үндэслэн тооцох, ямар шалгуур үзүүлэлттэй байх зэрэг зохицуулалт байхгүй байна.

Ийнхүү эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байна

Энэ нь нэг талаас Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол, эсхүл сэтгэцийн хор уршгийг тооцохдоо зөвхөн нотлох баримтад тулгуурлан эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримтыг харгалзан хохирлыг тооцож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн учирсан бодит хохирлыг шүүхээс тооцож байгаа бол эдийн бус хохирол болох сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршгийг хэрхэн тооцох нь тодорхойгүй байгаагаас хохирлыг тооцолгүй орхигдуулж байна.

Нөгөөтэйгүүр гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршиг хүлээсэн этгээд нь өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо нэхэмжилдэггүй, шүүхэд гаргасан цөөн нэхэмжлэлийг шүүхээс хэрэгсэхгүй болгодог зэргээр хүний эрхийг бодитой эдлүүлэх боломжоор хангахгүй байсан хэдийч өнөөдрийн байдлаар Монгол Улсад Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эцэслэн баталагдаж, хуулиар шүүх шинжилгээ хийх процессыг нарийвчлан зохицуулж, олон нийтийн дунд сэтгэл санааны хохирол гэж яригдаж ирсэн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шүүх шинжилгээгээр тогтоох, шүүх мөнгөн дүнгээр үнэлэх, хохирлыг барагдуулах үйл ажиллагааг тусгаж, эрүү, иргэний зэрэг хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж хуульчилсан.

Гэмт хэргийн хохирогчид сэтгэл санааны хохирлыг ялгамжтай тогтоож ирсэн байдал арилж, хүн бүрт хууль тэгш, хүртээмжтэй үйлчлэх боломж бүрдэж, хохирогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх харилцаанд ахиц дэвшил гарах боломжтой болсон гэж үзэж байна¹²⁸.

Хуульд сэтгэл санааны хохирлыг тодорхойлохдоо хүний сэтгэл зүйн хямрал янз янзын байдлаар илэрдэг ба энэ талаарх тодорхой аргачлалыг ХЗДХЯ болон ЭМЯ-аас баталж, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс сэтгэл зүйд учраад буй хямралын зэрэглэлийг тогтоож шүүх нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тодорхойлно гэж заасан байна.

Хүний сэтгэл санаанд учирч буй хор уршгийг мөнгөөр үнэлж баршгүй хэдий ч уг асуудлыг орхигдуулж болохгүй гэж үзэн Шүүх шинжилгээний тухай хуулиар шинэчлэн оруулж баталсан нь бидний нэг том алхам гэж үзэж байна.

Зарим Улс орнуудад иргэнээ хохироохгүйн тулд сэтгэл санаа, эд эрхтэн, амь насыг “үнэлдэг” жишиг олон улсад аль хэдийнээ тогтсон байна. Бусдын болон хууль шүүхийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болж зовж шаналсан, сэтгэл санаа тайван бус болсноос аз жаргалгүй болсон, мөн эд эрхтнээрээ тахир дутуу болж хөдөлмөрийн чадвар, амь насаа алдахад мөнгөн дүнгээр хохирол барагдуулдаг эрх зүйн орчин, туршлага бүрдсэн байдаг.

¹²⁸ ШШТХ-ийн 40 дүээр зүйл заасан

Тэр бүү хэл зарим улс оронд ёс суртахууны шинжтэй эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоо бүрджээ. Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг төлөх хөрөнгө буруутай этгээдэд байхгүй бол улсын төсвөөс гаргадаг. Ихэнх улс оронд сэтгэл санааны нөхөн төлбөр олгох улсын тусгай сан байдаг бөгөөд хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг жишиг бий.

Европын улс орнуудад сэтгэл санааны хохирлыг олгохдоо насны ангилал, хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, гоо сайхнаараа хохирсон эсэх, хөл, гар, тархины гэмтлийг нарийн харгалзан үзэж мөнгөн төлбөр өгдөг. Тухайлбал, Бельгид нүүрэндээ эдгэшгүй сорви авсан 16 настай хүүхдэд 18600 евро, Гааг дахь шүүхээс баруун нүдээ алдаж, хоёр жилийн турш ажиллах боломжгүй болж, хөдөлмөрийн чадвараа 15 хувь алдсан хүнд 20 мянган еврогийн нөхөн төлбөр, хөлөө гурван см тайруулж, 4, 12, 14 см-ын сорви авч, хичээл сургуулиа хойшлуулсан эмэгтэйд 14500 еврогийн нөхөн төлбөрийг олгожээ.

Гэтэл манай улсад өнөөг хүртэл эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг хэрхэн нөхөн төлүүлэхийг хуульд тодорхой зааж өгөөгүй. Сэтгэл санааны гэм хорыг тусгайлан авч үздэггүй нь амь нас, эрүүл мэндээрээ хохирсон, хилс хэргээр шийтгэгдсэн иргэд хохирч үлдэж байгаа юм.

Цөөн тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нэхэмжилдэг ч шүүхээс нотлох баримтгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог. Өөрөөр хэлбэл, манай өнөөгийн практикаар бол иргэн зовж шаналснаа шүүхийн өмнө нотлохоос өөр гарц шийдэлгүй байна. Тиймээс сэтгэл санааны хохирлыг төлдөг бусад улс орны жишгийг хүргэж байна.

Европын ихэнх орон хохирлыг нөхөн төлөх хоёр аргыг хэрэглэж байна. Зарим улс тодорхой өгөгдлийн бүдүүвч ашиглах буюу “нөхөн төлбөрийн хүснэгттэй улсууд” гэж нэрлэж болно. Мөн шүүгчийн үзэмжээр эрх зүйн практик дээр тулгуурлан хохирлыг барагдуулж байна. “Нөхөн төлбөрийн хүснэгттэй улсууд”-д Испани, Франц, Бельги, Итали, Чех багтдаг бол Герман, Швейцарь, Австри, Голланд, Польш “жишгийн эрх зүйт улсууд” юм.

Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирлыг үнэлэх, арилгах, зөрчсөн эрхийг сэргээх асуудлыг улс тус бүрээр нь авч үзье:

АНУ нь хувь хүний эд хөрөнгийн бус ашиг сонирхлыг мөнгөн төлбөр хэлбэрээр хамгийн үр нөлөөтэй хамгаалж, их амжилт олж байгаа улс юм. Английн эрх зүйгээс ялгарах америкийн өөр нэг онцлог бол “сэтгэл санаанд зориуд санаатайгаар хүнд дарамт учруулсан” («intentionally causing of severe emotional distress») тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ. Энэ деликтийн төлөө хүлээлгэх хариуцлагын үндсэн зарчим нь Деликтийн эрх зүйн (The Restatement (Second) of Torts, § 46, 1965) эмхэтгэлийн хоёр дахь засварт: “аливаа этгээд нь өөрийн онцгой болон доромжилсон зан үйлээр, санаатай буюу болгоомжгүй байдлаар бусад этгээдэд сэтгэл санааны хүнд дарамт учруулсан бол энэ сэтгэл санааны дарамтынхаа төлөө хариуцлага хүлээх ёстой¹²⁹” гэсэн агуулгаар илэрхийлэгдсэн байна.

¹²⁹ Bernstein R. D. First Amendment Limits on Tort Liability for Words Intended to Inflict Severe Emotional Distress// Columbia Law Review. 1985. Vol. 85. № 8. P. 1749. Falwell v. Flynt. № 83—0155 (April, 19. 1985) хэрэг нь жишээ болж болох юм. “Хустлер” (Hustler) сэтгүүл нь Жерри Фэлвелтэй хийсэн хошин ярилцлагандаа түүнийг “засаршгүй архичин” мэтээр гаргасан байна. Шүүх Фэлвелд 200 мянган долларыг сэтгэл санааны хүнд дарамтанд оруулсаны торгууль, нөхөн төлбөр хэлбэрээр олгохоор шийдвэрлэжээ

ОХУ, Украин. Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгоходоо буруутай этгээдээс нэхэмжилдэг. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашиглаж байна. Буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс олгодог. Нөхөн төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

Герман улсад. Гэмт хэргийн улмаас тодорхой этгээдэд оюун санааны, бие махбодын, эд хөрөнгийн хохирол учирдаг гэж үзнэ. Сэтгэл санааны хохирол нь ямар ч төрлийн гэмт хэргийн зайлшгүй үр дагавар байдаг бол бие махбодын болон эд хөрөнгийн хохирол нь гэмт хэргийн шинж чанараас хамаарна. Гэвч ямар ч тохиолдолд учирсан хор, хохирлыг арилгах, хохирогчийг хамгаалах асуудалтай байнга тулгарч байдаг.

Герман улсад сэтгэл санааны хохирол арилгах асуудлыг нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудаас өөрөөр шийдвэрлэнэ. Энэ нь юуны түрүүнд урд өмнө нь ёс суртахууны ашиг сонирхлыг бараг тооцож байгаагүй ромын эрх зүйн хүчтэй нөлөөгөөр тайлбарлагдана. Гэвч энэ үзлийг зарим эрдэмтэд буруу гэж үздэг. Сэтгэл санааны хохирлыг арилгах үзэл санаа ромын эрх зүйд зарим талаар тусгагдаж байсан нь эргэлзээгүй. Энэ үзэл санаа нь цэгцтэй хэлбэрээр илэрхийлэгдээгүй боловч энэ нь түүхэн хөгжлийн турш байнга хөгжиж, он цагийн урсгалд хохирол, алдагдлын тухай сургааль болон хөгжих нь дамжиггүй.

Германы шүүхүүд нь сэтгэл санааны хохирлыг арилгах зайлшгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хуулийн шууд заалтыг тойрон гарахын тулд нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс орнуудад сэтгэл санааны хохирол арилгах тогтолцоог ашиглах арга техникийг нэвтрүүлж эхлээд байгаа юм. Жишээлбэл, германы эрх зүй нь нийтлэг эрх зүйн нэгэн адил, хэрэв сэтгэл санааны хохирлыг арилгах нийтлэг зарчим байхгүй бол түүнийг яаравчлан хөгжүүлэх шаардлагатай гэж үздэг¹³⁰.

Белорусс Улс:

Хуулийн байгууллагууд нь хууль тогтоомжид заасны дагуу хүнд, онц хүнд гэмт хэргийн улмаас хүн ам хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эд хөрөнгө, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг бүрэн төлөх талаарх үндэсний болон олон улсын эрх зүйн нэг гол зарчмыг амьдралд нэвтрүүлэх талаар ихээхэн ажлыг хийж байна. Энэ асуудалд хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагуудын ажлын үр дүнг тооцоход энэ асуудал гол байр суурийг эзэлж байна. 2000 онд 1999 онтой харьцуулахад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах ажил нь 71.4% -иас 73% болж өссөн байна. Мөн виктимологийн урьдчилан сэргийлэх олон талт ажил зохиож эхлээд байна¹³¹.

Франц Улс:

Францын иргэний хууль нь эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлын ялгааг авч үздэггүй. Иргэний хуулийн 1149 дүгээр зүйл нь алдагдлыг

¹³⁰ Иеринг Р. Ф. Интерес в праве. Ярославль, 1880. С. 32.

¹³¹ Концепция статуса жертвы преступления в республике Беларусь и предупреждения виктимизации населения от тяжких насильственных преступлений. //Юстиция Беларуси, №3 2002. Минск., 2002.

тодорхойлохдоо, хохирлыг арилгах буюу нийт алдагдлыг арилгах тухай асуудлыг зөвхөн мөнгөн төлбөрөөр үл хязгаарлана. Сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирлыг арилгахын тулд хариуцагч нь хохирлыг арилгах гэм буруутай байх ёстой. Францын иргэний хууль нь түүний үүссэн шалтгаан нь деликт, эсхүл гэрээний зөрчил байсан ч үл хамаарч, оюун санааны хохирлын төлөө нөхөн төлбөр авах боломжтой учраас Германы иргэний хуулиас ялгаатай байдаг. Гэвч Франц улсад сэтгэл санааны хохирлыг арилгах хэмжээ нь нийтлэг эрх зүй (Common Law) үйлчилж байгаа орнуудаас бага байдаг уламжлалтай.

Францын деликтийн эрх зүйн үйлчлэлийн хүрээн дэх сэтгэл санааны хохирлыг арилгах институци нь иргэдийн дараах ашиг сонирхол, тухайлбал: бие, нэр төр, алдар хүндийн халдашгүй эрх; хувь хүний бодгаль чанарын бүх эрх /нэр, дүр төрхийн эрх орно/; мэргэжлийн үйл ажиллагааны болон захидал харилцааны нууцыг хадгалах эрх; зохиогчийн эрх; мэргэжлээ чөлөөтэй сонгох, чөлөөтэй зорчих эрх зэрэг ашиг сонирхлуудыг хамгаална.

Бельги Улс:

Эрүүгийн болон иргэний журмаар хохирол нөхөн төлүүлэх боломж нээлттэй бөгөөд хохирогч нэхэмжлэхийг өөрөө сонгох эрхтэй. Нийтийн сангаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно. Жишээ нь, амьдралаас таашаал авах боломжоо алдсаны хохирол, бэлгийн харилцааны хэм алдагдсаны хохирол, сэтгэл санааны тайван бус байдалд оруулсны хохирлыг эдийн бус гэм хорын хэлбэрээр тооцож барагдуулдаг.

-Хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсаны нэг өдрийн 25 евро

-Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсаны нэг өдрийн 13 евро

-Нэмэлт өвдөлт, шаналал зовиурт мөн нөхөн төлбөр өгнө.

Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хохирогчийг насны байдлаар нь ангилдаг.

-10 ба түүнээс доош настай хүнд 3300 евро

-35 ба түүнээс доош настай хүнд 2425 евро

-64 ба түүнээс доош настай хүнд 1410 евро.

Гоо сайхны хохирлыг 1-7 хүртэлх түвшингээр үнэлнэ.

-1-р түвшин 250-750 евро

-4-р түвшин 2250-8700 евро

-5-р түвшин 8700 евро ба түүнээс дээш

-7-р түвшин 24800 евро ба түүнээс дээш

Голланд Улс:

Гадаад гэмтэл /хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт/ 100-500 евро

-тархи хөдлөх / хөдөлмөрийн чадвараа алдсан 1 долоо хоногт / 300-1000 евро

-хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг гар хугарсан бол 600-2000 евро

-хүндрэлгүй эмчлэгдэх боломжтойгоор нэг хөл хугарсан бол 1250-3500 евро

-өвдөгнөөс доошх нэг хөлөө алдсан бол 15000-20000 евро

-нүд хараагүй бол нэг нүдэнд 15000-25000 евро

-нуруу сээрний гэмтлээс болж саажилт үүссэн бол 50000-аас дээш евро

Монгол Улсад сэтгэл санааны хохирлыг үнэлж буй аргачлал

Монгол Улсын Эрүүгийн хуульд “Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжлох /insult/”, мөн “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг /blackwash/ тараасан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан юм. Хэрэв гүтгэлгийг

хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол ялыг хүндрүүлэхээр заажээ.

Ийм учраас Монгол Улсад нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах гэмт хэрэгтэй тэмцэх, нөгөө талаас сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг эрүүгийн хуулиар хамгаалах асуудал хурцаар тавигдаж байна¹³².

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар “иргэний нэхэмжлэгч нь өөрийн эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх, сэргээлгэх эрхийг”¹³³ заасан юм. Ийм учраас эд хөрөнгийн бус хохирол нь амь нас хохирсон, эрүүл мэнд сарниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан үнэ өртгөөр илэрхийлэгддэггүй, гэм хор бөгөөд хохирогчийг санаа сэтгэлийн дарамтад оруулсан үр дагавар байна. Энэ үр дагаврыг: учирсан материаллаг гэм хорыг арилгах, сэтгэл санааны гэм хорыг мөнгөн төлбөрөөр нөхөн төлбөр гаргуулах, нэр төр, алдар хүндийг сэргээх зэргээр арилгана¹³⁴.

Монгол Улсын Иргэний хуулийн 230 дугаар зүйлд: “Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй” гэж заасан юм. Гэвч энэ хуульд зааснаар: “гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан юм. Ийм учраас эдийн бус гэм хорыг арилгах нөхөн сэргээх (төрөлх байдлаар), хуульд заасан бол нөхөн төлбөр (мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх) хэлбэрийг тогтоожээ¹³⁵.

Монгол Улсын Дээд Шүүхийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай” 2000 оны нэгдүгээр сарын 19-ний өдрийн 03 тоот тогтоолд:” нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн” талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирлын хэмжээг ихэнхдээ мөнгөн илэрхийллээр тогтоох боломжгүй бөгөөд дээрх үндэслэлээр хохирогчоор тогтоогдсон этгээд эд материалын хохирол хүлээснээ үндэслэл бүхий нотлох баримтаар нотолж хохирлын тухай тооцоогоо мөнгөн илэрхийллээр гаргаж ирсэн тохиолдолд шүүх түүнийг ердийн журмаар хянан шийдвэрлэх үүрэгтэй”¹³⁶ гэжээ.

Гэм хор учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан гэм хороос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн буюу эрх бүхий этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй) нөлөөлсөн бол гэм хорыг арилгах үүрэг болон түүний хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм бурууг харгалзана (ИХ 230.3§). Энэ

¹³² Үз.: С.Жанцан. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагааг эрүүгийн хуулиар хамгаалах зарим асуудал // Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2004. №1 (8). 19-20-р тал.

¹³³ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017. 8.6 дүгээр зүйл.

¹³⁴ Д.Наранчимэг. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. I дэвтэр. УБ., 1999. 89-р тал.

¹³⁵ Үз.: Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги. Туршилтын хэвлэл. УБ., 2005. 1030-р тал.

¹³⁶ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл. I. УБ., 2001. 205-р тал.

тохиолдолд: “хэрэв хүн өөрөө буруутай бол бүрэн хэмжээний хохирлыг шаардах эрхгүй”¹³⁷ гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгоно.

Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд боловсруулжээ.

Аргачлалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар товч харуулахад:

Алдагдсан боломжийн үнэлгээ

Сэтгэл санааны хохирлын үнэлгээ

Шууд зардал буюу баримтаар нотлогдох хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тооцоолохоор тогтоосон.

Алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ (АБХҮ):

Статистик мэдээнээс Монгол хүний дундаж наслалтын мэдээллийг авч, тэтгэвэрт гарах нас, ажил эрхлэх насны зөрүүгээр идэвхтэй ажиллах жилийг тооцоолно. Тухайн хохирсон хүний ажлаас гарсан өдрөөс тэтгэвэрт гарах өдрийг хүртэл тооцоолж нийт хэдэн өдөр ажиллах боломжоо алдсаныг сард (АБА) шилжүүлж сарын цалингаар (СЦ) үржүүлэн нийт цалингийн алдагдлыг гаргана.

$АБХҮ = АБА \text{ сарын тоо} * СЦ$

Шууд зардал буюу шууд хохирлын үнэлгээ (ШЗХҮ):

Шууд зардлыг тухайн хохиролтой холбогдон гарсан баримтаар нотлогдох эмчилгээний зардал (ЭЗ) болон бусад баримтаар нотлогдох зардлуудын (ББНЗ) нийлбэрээр тооцоолно.

$ШЗХҮ = ЭЗ + ББНЗ$

Сэтгэл санааны хохирлын үнэлгээ (ССХҮ):

Сэтгэл санааны хохирол тооцооллыг мөнгөн дүнгээр илэрхийлэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнийг (ДНБ) хүн амын тоонд харьцуулан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг (НХНДНБ) гаргаж үржүүлэгчээр (МХҮХ-ноос гаргасан 5.5) үржүүлэн хүний амь насны үнэлгээг гарна. Гарсан тоог хуанлийн хоногт (ХХ) харьцуулахад нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэлгээ (НӨССХСҮ) гарна.

Хохирлоос үүссэн үйлдэл байдал

Итгэлцүүр

Сэхээн амьдруулах

5.0

Мэс засал, хагалгаа

4.0

Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн

2.0

Зовиуртай байсан

2.0

Энгийн зовиур

1.0

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар

0-1.0

Энэхүү үржүүлэгч болон итгэлцүүрийг МХҮХ-ноос боловсруулан гаргасан болно.

Сэтгэл санааны хохирлын нийт үнэлгээг гаргахад эмнэлэгт хэвтсэн хоногийг (ЭХХ) дээр тооцоолон гаргасан сэтгэл санааны хохирол тооцох нэг өдрийн суурь үнэлгээг холбогдох итгэлцүүрээр үржүүлэн гаргана. Бусад дээрх итгэлцүүрт хамаарах хохирол үүссэн байвал энэ аргачлалаар тооцоолон гаргах боломжтой байна.

$ССХҮ = (НХНДНБ * \text{Үржүүлэгч}) / ХХ * ЭХХ * \text{итгэлцүүр}$

¹³⁷ Үз.: Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Ерөнхий анги. УБ., 2005. 1031-р тал.

Дээрх алдагдсан боломжийн хохирлын үнэлгээ, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, шууд зардлуудын хохирлын үнэлгээний нийлбэр нь эрүүл мэнд, сэтгэл санааны нийт хохирлыг (ЭМССХҮ) тооцоолох үнэлгээ болж байна.

ЭМССХҮ=АБХҮ+ШЗХҮ+ССХҮ138

Дээрх аргачлалын томъёоллын дагуу шүүхэд гомдол гаргасан иргэний сэтгэл санааны хохирлыг үнэлсэн жишээг харуулбал¹³⁹:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дундаж
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн /2018 он/	Сая.төг	32,306,653,450.00
2	Хүн амын тоо /2015-01-01/	Хүн	3,238,479.00
3	Нэг хүнд ногдох ДНБ	Мян.төг	9,975.87
4	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	5.50
5	Хүний амь насны үнэ /2016 оны байдлаар/	Мян.төг	54,867.30
6	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06
№	Цагдан хорих хугацааны сэтгэл санааны хохирол	Хэмжих нэгж	Тооцоолол
1	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06
2	Хоригдсон хоног 2018.11.06-2019.01.04	хоног	60.00
3	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	5.00
4	Хоригдсон хугацааны сэтгэл санааны хохирол дүн	Мян.төг	9,018.00
№	Хязгаарлалттай хугацааны сэтгэл санааны хохирол	Хэмжих нэгж	Тооцоолол
1	Нэг өдрийн сэтгэл санааны хохирлын суурь үнэ	Мян.төг	30.06
2	Хоригдсон хоног 2018.11.05-2019.10.23	хоног	291.00
3	Үржүүлэгч /МХҮХ-ноос тогтоосон/	Итгэлцүүр	4.00
4	Хоригдсон хугацааны сэтгэл санааны хохирол дүн	Мян.төг	34,994.81
№	Сэтгэл санааны хохирол тооцоолол	Хэмжих нэгж	Нийт дүн
1	Цагдан хорих хугацааны сэтгэл санааны хохирол	Мян.төг	9,018.00
2	Хязгаарлалттай хугацааны сэтгэл санааны хохирол	Мян.төг	34,994.81
	Нийт дүн		44,012.81

Дээрх Монгол Улсын иргэний сэтгэл санааны хохирлыг тооцсон жишээг ОХУ-ын эрдэмтдийн зохиосон сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалаар тооцоолбол:

¹³⁹2016 онд Монголын хохирол үнэлгээчдийн холбооноос “сэтгэл санааг тооцох аргачлал”

1. **В.Я. Понаринийн сэтгэл санааны хохирол (ССХ) тооцох арга.** Үүнд ССХ тооцох 2 аргачлал багтсан: өдрийн үзүүлэлт болон хориг арга хэмжээний үзүүлэлт. Эхний аргачлалыг хэрэглэхэд:

$$ССХ = n \times Д,$$

Тухайн хохирогчийн дундаж цалин тооцоолол

$$19\ 145\ 450 = 1200000 / 22 \times 351$$

n - шүүх ССХ нэхэмжлэх өдрүүдийн тоо

$Д$ - шүүгдэгчийн нэг өдрийн дундаж орлого.

Ийм тохиолдолд ССХ нь зөвхөн шүүгдэгчийн орлогоос хамаарна, хохирогчийн тарчлал, түүний хувь хүний шинж чанар тооцогдохгүй байна.

2. **ОХУ-д Эрделевскийн доорх томъёог ашиглан сэтгэл санааны хохирлыг** тооцож байна.

Эрделевскийн хүснэгтийг бусад улс орон загвар болгон ашиглах тохиолдол бий. Эрделевскийн хүснэгтэд $D = d \times f_v \times i \times c \times (1 - f_s)$ буюу D - Сэтгэл санааны хохирлын нийт дүн, d – Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ, f_v - Гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0-ээс их нэгээс бага байх бөгөөд i - хувь хүний онцлог өөрөөр хэлбэл тухайн хохирогч нь сэтгэл санааны хувьд дунд зэргийн байдалтай бол $i = 1$, хэрэв сэтгэл санааны хувьд хүндээр тусгаж авсан бол $i > 1$, харин эсрэгээрээ байхын бол $i < 1$ байна. Хохирогч өөрөө сэтгэл санааны хувьд тогтвортой, гомдолгүй бол $i = 0$ байна.

C - хор хөнөөл учруулсан бодит нөхцөл байдлын итгэлцүүр.

I, C – гэмт хэргийн төрөл бүр нь тодорхой онцлог шинж чанараар 0-2 итгэлцүүрээр тодорхойлогддог.

f_s – хохирогчийн гэм буруутай байдлыг харгалзан үздэг байна.

Хүснэгт:

Зөрчил	Нөхөн төлбөрийн хэмжээ	
	Итгэлцүүр	Цалингийн доод хэмжээ
Бие махбодид хүнд гэмтэл учруулах	0,80	576
Хэрвээ хохирогчийг зовоон тарчлаасан бол (тамласан)	1,00	720
Бие махбодид дунд зэргийн гэмтэл учруулах	0,30	216
Хэрвээ хохирогчийг зовоон тарчлаасан бол (тамласан)	0:5	360
Бие махбодид хөнгөн гэмтэл учруулах	0,03	24
Зодох	0,025	18
Тамлах	0,30	216
Хүн алах, хүний бие махбодид хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх	0,20	144
Хүний эрхтэн, эд эсийг шилжүүлэн суулгахыг шаардах	0,40	288
Бусдаас хамааралтай болон хүнээс шаардах	0,5	360
Бэлгийн замын халдварт өвчин халдаах	0,05	36

ДОХ халдаах	0,50	360
Өвчтөнд тусламж үзүүлээгүйгээс болоод өвчтөний эрүүл мэндэд дунд зэргийн хохирол учруулах	0,03	24
Өвчтөнд тусламж үзүүлээгүйгээс болоод өвчтөний эрүүл мэндэд хүнд зэргийн хохирол учруулах	0,30	216
Хүн хулгайлах	0,80	576
Бие махбодийн зовлон учруулсан тохиолдолд	1,00	720
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	1,50	1080
Хууль бусаар хүний эрх чөлөөг хязгаарлах (нэг өдрийн)	0,30	216
Бие махбодийн зовлон учруулсан тохиолдолд	0,50	360
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	0,80	576
Сэтгэцийн эмнэлэгт хууль бусаар байрлуулсан (нэг өдрийн)	0,30	216
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан тохиолдолд	0,70	504
Хуурамч, нэр төр гутаасан мэдээлэл түгээх	0,03	24
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	0,05	36
Хүнд гэмт хэрэгт холбогдсон мэдээлэл түгээсэн тохиолдолд	0,30	216
Доромжлох	0,015	12
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	0,03	24
Хохирогчийн хүчирхийлэл, заналхийлэл, хохирогчийн бие авч явах чадахгүй байдлыг ашиглан бэлгийн харьцаанд орох эсвэл бэлгийн шинжтэй бусад хүчирхийлэл үйлдэх	0,60	432
Хүн алах, хүний бие махбодид хүнд гэмтэл учруулахаар заналхийлсэн тохиолдолд	1,00	720
Эрүүл мэндэд хүнд буюу дунд зэргийн хохирол учруулсан эсвэл ДОХ халдаасан тохиолдолд	1,50	1080
Өөрийхөө автанд оруулах, сүрдүүлэх замаар бэлгийн шинж чанартай үйлдэл хийхийг албадах	0,10	72
Иргэний ялгаварлан гадуурхалт	0,20	144
Хувийн нууцлалыг зөрчих	0,03	24

Утасны яриа, захидал болон шуудан холбооны мэдээллийн нууцлалыг зөрчих	0,03	24
Гэрийн халдашгүй байдлыг зөрчих	0,025	18
Хүчирхийлэл ашигласан болон сүрдүүлсэн тохиолдолд	0,20	144
Иргэдэд мэдээлэл өгөхөөс хууль бусаар татгалзах	0,025	18
Сонгуулийн эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах	0,03	24
Ажилд авахаас хууль бусаар татгалзах	0,03	24
Хууль бусаар ажлаас халах	0,1	72
Хөдөлмөрийн бусад эрхийг зөрчих	0,05	36
Зохиогч, зохион бүтээгчийн оюуны өмчийн эрхийг зөрчих	0,20	144
Шашин шүтэх эрх чөлөөг зөрчих	0,025	18
Хүүхэд үрчлэх болон үр шилжүүлэн суулгах нууцыг задруулах	0,20	144
Хүүхэд солих	0,50	360
Хэрэглэгчийн өмчийн эрхийг зөрчих	0,05	36
Их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд	0,20	144
Ойр дотны хамаатныхаа үхэлд хүргэх	0,30	216
Харгисаар үхэлд хүргэсэн тохиолдолд	0,80	576
Ойрын хамаатныхаа цогцос буюу булшид зүй бусаар харьцах	0,025	18
Гэмгүй хүнийг хэлсээр эрүүгийн хариуцлагад татах	0,50	360
Хүнд гэмт хэрэгт тулгах	1,00	720
Гэмгүй хүмүүсийг буруутгах	0,40	288
Ноцтой үр дагавар дагуулсан	1,00	720
Хууль бусаар баривчлах	0,20	144
Хууль бусаар цагдан хорих (нэг өдрийн)	0,04	28,8
Хууль бусаар эрх чөлөөг хязгаарлах бусад тохиолдлууд (нэг өдрийн)	0,01	7,2
Мэдүүлэг өгөхийг албадах	0,30	216
Хүчирхийлэл хэрэглэсэн болон тамласан хослуулан	0,80	576
Эрх бүхий байгууллага, захиргааны хууль бус үйлдэл, шийдвэрээр иргэний эрх, эрх чөлөөг бусад хэлбэрээр зөрчих	0,05	36

Их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд	0,20	144
---	------	-----

Итгэлцүүрийг сонгох үзүүлэлтүүдийг харуулбал:

Сэтгэл санааны хүнд зэргийн хохиролтой хохирогч хүнд зодуулсан хүн нь бие мах бодь болон сэтгэл санааны хохирлын хувьд өөр өөрийн онцлогтой. Хүнд зодуулж бие мах бодийн гэмтэл авсан бол тодорхой хугацаанд эмчлэгдэж болдог бол сэтгэл санааны хохирлыг тэр хэмжээгээр эмчлэх боломжгүй гэж үзэж байна. Тухайн хохирогч хүнд зодуулсны дараа өвчин мэдэрч буй байдал нь их багаас шалтгаалан I итгэлцүүр нь 1-ээс дээш буюу доош гэж тодорхойлно.

Хэрвээ жирэмсэн хүн зодуулаад хүүхэд зулбуулсан бол тухайн иргэн дахин хүүхэд тээх боломжтой юу гэдгээс шалтгаалан итгэлцүүр нь өөр өөр байна.

- Хэрэв тухайн эмэгтэй санаатайгаар зодуулсан бол /жирэмслэлтээ зогсоох санаатай бол/ сэтгэл санааны хохирол байхгүй шүүгч I итгэлцүүр байхгүй гэж үзнэ.

- Хэрэв тухайн зодуулсан жирэмсэн эмэгтэй урд өмнө удаа дараа аборт хийлгэж байсан бол 0,5 итгэлцүүр

- Зодуулсны дараа хүүхэд тээх боломжтой бол – 1 итгэлцүүр

- Эмчилгээ хийлгэх шаардлагатай бол – 1,5 итгэлцүүр

- Хэрэв зовоон тарчлаасан бол /тамласан/ 2 итгэлцүүр

- Хүүхэд тээх бүүр боломжгүй гэж үзвэл 2 итгэлцүүр

Хэрэв ойрын хамаатан нас барсан бол ямар хамаатнаас шалтгаалж:

- Хэрвээ гэр бүлийн гишүүн бол хэр удаан хугацаанд амьдарч байсан итгэлцүүр өсөх

- Цаашид гэрлэх үү үгүй юу гээд насыг харгалзаж үзэх итгэлцүүр нь өөрчлөгдөх

- Нас барсан хохирогчийн хамаатан садан тус бүр нь сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх үүснэ

Хэрэв хохирогчийн нэр төрд халдсан бол итгэлцүүрийг тооцоолоход нэр төр гутаасан шинж чанараас хамаарна. /хамрах хүрээ, үр дагавар/ /Нэр төрийг гутаан доромжлохдоо хэр өргөн хүрээнд тараасан, бас хэр олон мэдээллийн хэрэгслээр тараасан/

Хохирогчийн итгэлцүүрийг тодорхойлохдоо тухайн хохирогчийн зан чанар характерыг судалж үзэж байж тодорхойлдог

Үр дагавар нь:

- Ажлаас халагдах
- Сонгох эрх, нөлөөнд хууль бусаар халдсан
- Гэр бүл салах гэх мэт...

Ажлын байран дээр нэр хүндэд халдсан байдал

Хэрэв хууль бусаар хүний эрхийг хязгаарлаж саатуулсан тохиолдолд итгэлцүүр i- 1 болно.

Хэрэв хохирогчийг барьцаалан хууль бусаар эрхэнд нь халдсан тохиолдолд **итгэлцүүр с- 1** ба түүнээс дээш байна.

- Хэрэв хууль бусаар ял эдэлсэн тохиолдолд:
- Хохирогч хэрэв өмнө нь ял эдэлж байсан бол өмнө нь ял эдэлж байгаагүй хохирогчоос итгэлцүүр нь 1-ээс бага байна

- Нэг хүнд оногдох талбайн хэмжээнээс хамаарна /ялын төрлөөс, бусад хоригдлуудыг дарамталсан, зөрчил гаргах, хорих ангийн журмыг зөрчих, ажил дээр сөрөг үр дагавар/ гарсан зэрэг байдлаас хамаарч итгэлцүүр **С-г** өсгөх буюу бууруулна
- Хувь хүний бүрэн эрхийг хязгаарлах:
- Өөрийн хүсэлгүй бэлгийн харилцаанд оруулах
- Бэлгийн чиг хандлагыг нь албадан өөрчлөх
- Мэргэжлийн бие үнэлэгч хүчиндүүлсэн бол итгэлцүүрийг багасгаж тооцох гэх мэт...
- Хохирол учруулахдаа ямар нөхцөл байдалтай байсан талаар /хүчиндэх үед хүний биед хохирол учруулсан байдал, бэлгийн замын халдварт өвчин авах, хүчингийн улмаас жирэмслэх, хүүхэд эхнэр, нөхрийн өмнө эсвэл бусдын өмнө хүчиндэх, гэр бүл салах, сэтгэцийн өвчтэй/ зэргээс хамаарч **С итгэлцүүр** өөрчлөгдөнө.
- Согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсний улмаас /эсвэл өөрөө өдсөн бол/ хүчиндүүлсэн тохиолдолд итгэлцүүрийг бууруулж тооцно.
- Хувь хүн /хуулийн этгээдийн/ нууцыг задруулах
- Банк санхүүгийн байгууллага хувь хүн, хуулийн этгээдтэй холбоотой дансны мэдээллийг нийтэд дэлгэх /түүнээс хамаарч тухайн хохирогчийн санхүүгийн байдал дордсон бол **С итгэлцүүр 2 болно/**
- Эмчлэгч эмч өвчтөний өвчний түүхийг задруулах /үр дагавраас хамаарч итгэлцүүр нь өсөх буюу буурна/

Fs – хохирогчийн гэм буруугийн зэрэг 0-1

Тухайн хохирогчийн өөрөө зорилготойгоор хохирол амсаж сэтгэл санаанд хохирол үүссэн бол f_s-1 гэж үзээд өөрөөр хэлбэл сэтгэл санааны нөхөн төлбөрийг олгохгүй 0 гэж үзнэ. $D=d*fv*i*c*(1-fs)$.

Хэрэв тухайн хохирогч нь өөрөө буруугүй тохиолдолд сэтгэл санааны хохирол учирсан бол F_v – ийг орхиж тооцоолно. $D=d*i*c*(1-fs)$

$$420000=d*0.3*2(1-0) \quad d=27\,300\,000$$

4. А.Л. Южаниновагийн ССХ тооцох арга.

Дараахь бүтэцтэй томъёог санал болгосон:

$ССХ = (\text{биеийн тарчлалын хэмжээ} + \text{сэтгэл зовнилын хэмжээ}) \times (\text{үр дагавар}) \times (\text{нөлөөллийн мөн чанар})$

Южаниновагийн тооцооллоор Тарчлалын зэрэг нь бие махбодын зовлон зүдгүүр, тарчлал нь (хүнд, дунд, хөнгөн), түүний үр дагавар (үйл ажиллагаа, органик, архаг), түүнчлэн бие махбодийн зовлонтой холбоотой (хүчтэй, дунд зэрэг, сул) үнэлэгдэх ёстойг харгалзан үздэг. Харамсалтай нь биеийн тарчлалын хэмжээ болон сэтгэл зовнилын хэмжээг тодорхойлох томъёо байдаггүй. Гэсэн хэдий ч шинжээчдийн аргыг ашиглах боломжтой.

5. Е.Н. Холоповагийн ССХ тооцох арга.

ССХ-г дараах томъёогоор тооцоолно:

$$ССХ = ССХДХ \times Хб \times Бб \times Ис$$

ССХДХ - хууль тогтоогчоор тогтоосон сэтгэл санааны хохирлын доод хэмжээ,

Хб - хохирогчийн буруугийн итгэлцүүр,

Бб - Буруутай этгээдийн буруугийн итгэлцүүр,

Ис - Сэтгэл зүйн итгэлцүүр эсвэл хувь хүний шинж чанарын итгэлцүүр.

Г.Г. Горшенковийн ССХ тооцох арга.

ССХ-г дараах томъёогоор тооцно:

$$\text{ССХ} = \text{Иш} \times \text{ХХДХ} \times \text{Иэ},$$

Иш - шийтгэлийн дундаж индекс (жишээ: хүчингийн хэрэгт (ОХУ-н Эрүүгийн Хууль 131 заалт): 1-р хэсэг - 3-аас 6 хүртэлх жилээр эрх чөлөө хязгаарлах; 2-р хэсэг - 4-өөс 10 жил; 3-р хэсэг - 8-аас 15 жил. Эндээс $\text{Иш} = 3 + 6 = 9/2 = 4,5$; $\text{Ин} = 4 + 10 = 14/2 = 7$; $\text{Ин} = 8 + 15 = 23/2 = 11,5$.

ХХДХ - хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;

Иэ - эрүүл мэндийн хохирлын итгэлцүүр (ОХУ-н Эрүүгийн Хуулийн 111-115).

Горшенков өөрийн арга зүйгээ зөвхөн субъектив алдагдал, тэдгээрийн нөхөн төлбөрийн хэмжээг эрх зүйн үнэлэмжээр үнэлэх шалгуурын тогтолцоог боловсруулах анхны санаа гэж үздэг.

7. А.В. Черкуновагийн ССХ тооцох арга.

Судалгаан дээр ССХ-г энэхүү томъёогоор тооцоолсон.

$$\text{ССХ}_{\text{х.э.}} = (\text{ССХ}_{\text{х.х.с.}} + \text{ССХ}_{\text{х.х.б.}})$$

ССХ х.э. - хуулийн этгээдийн сэтгэл санааны хохирлын нөхөн олговор.

ССХ х.х.с - хувь хүний сэтгэл санааны хохирлын нөхөн олговор

ССХ х.х.б.-хувь хүний бие махбодийн хохирлын нөхөн олговор

Хуулийн этгээдийн хувь хүн гэдэгт байгууллагын удирдлага (захирал, үүсгэн байгуулагч-хувь хүн), сэтгэл санааны хохирол амссан ажилтнууд орно. Хувь хүн бүрт учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг ажлын үр дүнгийн байдлаар тодорхойлно [8].

Судалгаан дээр ССХ-г тооцоолох томъёог санал болгож байна:

$$\text{КМВ} = \text{Ач} \text{ Есм} \text{ U} \text{ Тсм}$$

Ач - хэмжих нэгж бууруулах итгэлцүүр,

Есм - тарчлалд зарцуулсан эрч хүч

U-эрч хүчийн хэлбэлзлийн давтамж

Тсм-тарчлалын цаг

Дүгнэлт, санал

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг бодитой тогтоох шийдвэрлэх, нөхөн төлүүлэх нь хууль зүйн болон нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн бөгөөд эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол, хор уршгийг барагдуулах талаар гадаад улс орны аргачлалаас ОХУ-ын эрдэмтдийн боловсруулсан аргачлалд цалингийн доод түвшин болон дотоодын нийт бүтээгдэхүүнийг хохирол тооцоолох суурь үзүүлэлтээр тооцоолж байгаа нь манай орны үнэлгээний байгууллагуудын хэрэглэж байгаа суурь үзүүлэлт ашиглах аргачлалтай ижил байна.

Монгол Улсын иргэнийг гэм буруутайн тогтоодоггүй байхад эрхийг хязгаарласан, цагдан хорьсон хугацааны сэтгэл санааны хохирлын үнэлгээг тогтооход оролцсон туршлагаасаа авч үзэхэд:

- ✓ Хохирогч нь тухайн хугацаанд эрхэлсэн ажилгүй;

- ✓ Хохирогч нь ажлаа үргэлжлүүлэн хийх бололцоотой ч хуучин ажлын удирдлагын зүгээс итгэлгүй хандаж, ажил, албан тушаалд эргүүлэн авмааргүй байгаагаа илэрхийлсэн;
- ✓ Өргөдлөө өгөхийг хохирогчоос хүсэж, шинэ хамт олон дунд хэл аманд орооцолдон хэрэгт шалгагдаж байсан хүн орж ажиллах нь нийгэмд сөргөөр харагдах гээд байгаа талаар тайлбарлаж байгаа нь хохирогчийн бие организмд бодит байдлаар болон орчноос хүртэх сэтгэл санааны хохирол гэж үзэхээр байсан.
- ✓ Хохирогчийн ар гэр болох өндөр настай эцэг эх, эхнэр, өсвөр насны хүүхэд, түүний хүрээлэн буй орчин, найз нөхөд нь энэ хугацаанд танай хүү, нөхөр, аав, найз албан тушаалаа урвуулан ашигласан хэрэгтэн гэж дуудуулж байгаа нь хохирогчид болон ойр дотнын хүмүүст сэтгэл санааны ихээхэн хохирол учруулсаар байхаар байсан боловч шууд хохирлыг тооцоолсноос ойр дотнын дам хохирлыг тооцоолох боломжгүй байгаа нь үнэлгээний явцад харагдаж байсан. Үүнээс үзэхэд сэтгэл санааны хохирол нь тухайн иргэний асуудал биш ойр дотнын хүмүүс мөн адил хохиролд өртдөг боловч энэ талаар манай оронд одоогоор хохирол нэхэмжилсэн түүхэн мэдээлэл гараагүй буюу шийдвэрлээгүй байна.

Гадаад улс орнуудын сэтгэл санааны хохирол арилгах аргачлалыг Монгол Улсад хэрэглэж байгаа аргачлалтай харьцуулан үзэхэд дээрх аргуудаас ОХУ–д Эрделевскийн сэтгэл санааны хохирол тооцох аргачлал нь ойролцоо байна. Бидний гарган ашиглаж байгаа итгэлцүүрийг шүүх эмнэлгийг сэтгэц гэм судлалын шинжлэх ухаантай хослуулан хөгжүүлж хохирогчийн сэтгэл санааны хохирол тооцох жишиг аргачлалын итгэлцүүрийг гаргах шаардлагатай байна гэж үзлээ.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2016
2. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2017
3. <https://police.gov.mn/resource/policegovmn/File/2018/11/06/n3vggzukdbbb4vmw/1.%202018.10%20sar%20medee%20Burtgedgsen%20hereg.pdf>
4. Монгол улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал 2017
5. Квашис В.Е. Основы виктимологии. М., 1999. С.179-185.
6. Квашис В.Е. Основы виктимологии. М., 1999.С.218.
7. Lab, S. P. (1997). Crime Prevention: Approaches, Practices and Evaluations. Third Edition. Cincinnati, OH. Anderson Publishing Company.
8. Prosser W. L. Privacy//Calif. Law Review. 1960. Vol. 48. P. 388—392.
9. Постановление Пленума Верховного суда РФ от 20.12.1994 г. № 10 «Некоторые вопросы применения законодательства о компенсации морального вреда» // Российская газета. № 29. 08.02.1995
10. Шнайдер Г.И. Криминология М., 1994.С.364-365.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРЛИЙГ БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЯЛЫН ТӨРӨЛТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

TYPES OF PUNISHMENT IN CRIMINAL LAW OF MONGOLIA TYPES OF PENALTIES UNDER PRC CRIMINAL LAW COMPARATIVE STUDIES



С.Ууганбаатар

Дотоод хэргийн их сургуулийн

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахмад*

Товч утга: Монгол улсын хувьд газар зүй геополитекийн мөнхийн хөрш болсон ОХУ, БНХАУ-ын улс төр, нийгэм эдийн засгийн байдал, соёл уламжлал, зан заншил, эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомж зэргийг зайлшгүй судлах шаардлагатай билээ. Монгол улсын Эрүүгийн хуулийн ялын төрлийг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн ялын төрөлтэй дараах эх сурвалжийн хүрээнд харьцуулсан судаллаа.

Түлхүүр үгс: Монгол улс, эрүүгийн хууль, ялын төрөл, ялын бодлого, эрүүгийн хариуцлага, эрх зүй, хэм хэмжээ.

Abstract: For Mongolia, it is necessary to study the political, socio-economic situation, culture, traditions, customs, legal system and laws of Russia and China, which are the eternal neighbors of geography and geopolitics. The types of punishments under the Criminal Law of Mongolia have been compared with the types of punishments under the Criminal Law of the People's Republic of China in the context of the following sources.

Keywords: Mongolia, criminal law, type of punishment, punishment policy, criminal responsibility, law, norms.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын их хурлаас Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн баталж, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна.

БНХАУ-ын эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хуралдаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр